

БАРУУН-УРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 9 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ

Албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр:Тайлант сарын байдлаар Тамгын газраас 45 бичиг явж, 44 бичиг ирсэн байна.

Албан бичгийг удирдлагад танилцуулан цохолт хийлгэж холбогдох мэргэжилтэнд бүртгэлээр хүлээлгэн өгч, хариу барагдуулан эргэх холбоотой ажиллалаа.

Хариутай 9 албан бичиг ирснээс хугацаандаа 8 албан бичиг явсан. Хугацаа болоогүй 1 бичиг байна. Хугацаатай албан бичгийн барагдуулалт 100% байна.

Тайлант сард багийн Засаг даргын албан тодорхойлолтыг 350 иргэнд гаргаж үйлчилсэн байна.

Сумын Засаг даргын “А”захирамж-44, “Б” захирамж-4, Тамгын газрын даргын “А” тушаал- “Б” тушаал-10 тус тус гарсан.

Байгууллагын архиваас нийт 65 лавлагаа олгож, бүртгэл хөтөлсөн.

Баруун-Урт сумын "Төрийн үйлчилгээний оператор" нь 22 төрлийн лавлагааг 122 иргэнд гарган үйлчилсэн.

Байгууллагын мэдээллийн цагийг мягмар гараг бүр зохион байгуулж тэмдэглэл хөтлөн, үүрэг даалгаврыг албажуулж ажилласан.

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР:

Сумын Засаг даргын “А”захирамж-44, “Б” захирамж-4, Тамгын газрын даргын “А” тушаал- “Б” тушаал-10 нийт 58 шийдвэрийн хууль эрх зүйн үндэслэлийг хянаж, зөрчлийг арилган ажиллаж байна.

3 дугаар улирлын байдлаар Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд хандаж 1200 өргөдөл, гомдол ирснийг хүлээн авч, хариу мэдээлж, эргэх холбоотой ажилласан. Өргөдөл, гомдлын барагдуулалт 97%-тай байна. Өргөдөл, гомдлын улирлын тайланг гарган аймгийн Төрийн захиргаа удирдлагын хэлтэст хугацаанд хүргүүлсэн.

Ухаалаг засаглал төрийн бус байгууллагатай хамтран төрийн удирдлагын мэдээллийн цахим системийг байгууллагад нэвтрүүлэн, гүйцэтгэлийн төлөвлөгөө цахимд шилжүүллээ. Уг ажилд Тамгын газар, 5 тасаг нэгж, 25 албан хаагч хамрагдсан.

Төлөвлөгөөний дагуу байгууллагын дотоод хяналт зохион байгууллаа. Үүнд:

-2022 оны хөгжлийн төлөвлөгөөнд 6 бүлэг 18 зорилт 52 арга хэмжээг тусгаснаас дараах арга хэмжээнүүд тасарч байна. Үүнд:

- Орон нутгийн төсөв, бусад төсөл хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр эрүүл мэндийн төвийн авто машины шинэчлэл, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ
- “Малчны залуу халаа” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана.
- Үйлчилгээний байгууллага, иргэдэд аялал жуулчлалын менежментийн талаар боловсрол олгох, тэдний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих, үзэсгэлэнд оролцуулах.
- Барилгын хатуу хог хаягдлыг байгаль орчинд халгүй аргаар устгах, дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжиж ажиллана.
- Гэр хорооллын нүхэн жорлонг ариутгаж халдваргүйтгэл хийх
- Нийтийн эзэмшлийн зам талбайд хогийн савыг шинэчлэх

-Аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний 15 чиглэлд 69 арга хэмжээг хяналт авснаас доорх 2 арга хэмжээ тасарсан байна. Үүнд:

- Залуу малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч залуучууд, зорилтот бүлгийн залуучуудыг оролцуулан “Шинэ үеийн илгээлтийн эзэд” арга хэмжээг зохион байгуулах
- “Эко жорлон” арга хэмжээний хүрээнд төв, суурин газрын гэр хорооллын нүхэн жорлонг үе шаттайгаар стандартын шаардлагад нийцүүлэх

Тамгын газрын жилийн ажлын төлөвлөгөөг төрийн удирдлагын мэдээллийн цахим системд бүрэн шивсэн.Үүнд:

- Нэг.Бодлогын баримт бичиг болон хуулиар тусгайлан олгосон чиг үүрэгт 2 зорилтын хүрээнд 9 арга хэмжээ
- Хоёр.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж 1 зорилтын хүрээнд 3 арга хэмжээ
- Гурав.Хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг 6 зорилтын хүрээнд 6 арга хэмжээ
- Хуулиар олгосон нийтлэг чиг үүрэг 1 зорилтын хүрээнд 3 арга хэмжээ нийт 35 зорилтын хүрээнд 98 арга хэмжээг тус тус төлөвлөсөн байна. Үр дүнгүй арга хэмжээ-, үр дүнтэй 50, тодорхой үр дүнд хүрсэн-31 арга хэмжээ байна. Эрчимжүүлэх шаардлагатай 17 арга хэмжээг албан хаагч тус бүрд танилцуулж, гүйцэтгэлд анхаарах талаар зөвлөгөө, чиглэл өгч ажиллалаа.

Цаашид байгууллагын төлөвлөгөөг боловсруулахад дараах чиглэлд анхаарах шаардлагатай байна. Үүнд:

- Байгууллагын стратеги зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ төлөвлөх.
- Төлөвлөгөөг боловсруулахдаа стратеги төлөвлөгөө болон бусад бодлогын баримт бичигтэй уялдуулан, зорилт, шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, тухайн жилийн хүрэх түвшин, гүйцэтгэл, үр дүнг тооцсон байх.

- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын дагуу байгууллагын гүйцэтгэлийн зорилтын төрлийг оновчтой тодорхойлж төлөвлөх.
- -аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 6 бүлэг 168 арга хэмжээ, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 6 бүлэг 177 арга хэмжээг тус тус хяналтад авч биелэлт, үр дүнг тооцон ажиллаж байна.Хяналтын дүнд зөрчил арилж, ажил сайжирсан.

Зөв хэвшил-зөв амьдрал хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын хүрээнд ерөнхий боловсролын 4 сургуулийн эко клубын сурагч нартай хамтран Хайр түгээх үү хог түгээх үү арга хэмжээ зохион байгуулсан. Уг арга хэмжээний хүрээнд дахин боловсруулах боломжтой бүтээгдэхүүнээр цэцгийн баглаа, үзэгний, ээмэг, бөгжний, ангилан ялгалтын хог хаягдлын сав, гар утасны кэйс, цаасан уут, зэргийг хийж үзэсгэлэн гаргасан. Сурагчид хог хаягдлыг дахин боловсруулах, эдийн засгийн эргэлтэд оруулах, ангилан ялгах, талаар мэдээ, мэдээлэл, нөлөөллийн ажлыг зохион байгуулсан. Мөн иргэдийн дунд танин мэдэхүйн аха тэмцээн, амьдралын зөв хэвшилд уриалсан шүлэг зохиох уралдааныг тус тус зохион байгуулсан. Уг нөлөөллийн арга хэмжээнд нийт 95 иргэн идэвх санаачилгатай оролцсон. Арга хэмжээний үеэр нийт 8 тонн хог хаягдлыг түүж цэвэрлэсэн. Үүний 3 тонн нь хуванцар, 1 тонн цаас, 4 тонн нь бусад хог хаягдал тус тус эзэлж байсныг мэргэжлийн байгууллагад хүлээлгэн өгсөн.



Тус клубын 25 сурагчтай хамтран эерэг хандлага, зөв дадлыг хамтдаа хэвшүүлье, архи 10 нас, тамхи 5 нас хорооно гэсэн уриалгыг бэлтгэн Найрсаг Баруун-Урт театр өдөрлөгт оролцсон 58 төрийн байгууллага, 38 аж ахуй нэгж, 5000 гаруй иргэдэд

түгээж ажилласан.Уг нөлөөллийн ажлыг хэрэгжүүлэхэд мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас 150000 төгрөг зарцуулсан.



7-р багийн ажлын албанаас архины хамааралтай 1 иргэнийг Сэтгэц наркалогийн тасагт хэвтэн эмчлүүлсэн. Мөн архины хамааралтай 1 иргэнийг эмчлүүлэхээр үзлэгт хамруулж, очер дугаарт оруулаад байна.

Эрүүл аж төрөх соёл

сургалтад 4-р багийн 10 иргэнг хамруулж амьдралын зөв хэвшил, дадал олгон, аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, гэр бүлдээ хэрхэн үнэ цэнэтэй амьдрах талаар мэдээлэл өгч ажиллалаа.

ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР: Сумын хүн амын гол нэрийн бүтээгдэхүүний хүнсний аюулгүй байдалд хяналт, шалгалт хийлээ. Баруун-Урт сумын 3 дугаар багийн иргэн нь хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангахад шаардагдах ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангаагүй улмаас үйл ажиллагааг зогсоох чиглэл өгч, мэргэжлийн байгууллагатай холбон чиглүүлж, туслалцаа өгч ажиллалаа.



Баруун-Урт театр өдөрлөгт хүнс худалдааны чиглэлээр нийт 38 аж ахуй нэгж, иргэн оролцож бараа бүтээгдэхүүнээ борлуулж 11500000 мянган төгрөгний орлого олсон. Мөн аж ахуй нэгжүүдийн дунд 5 төрлөөр номинациар шалгаруулж, урамшуулсан.



Баруун-Урт суманд үйл ажиллагаа явуулж байгаа 8 бойны цэгт төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулсан бөгөөд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хүчин чадал, ажилчдын тоо тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа эсэх талаар мэдээ мэдээллийг шинэчилж ажиллалаа.



НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР: Баруун-Урт сумын ахмадын холбооны хурлаас шинээр сонгогдсон дарга тэргүүлэгчдэд хүндэтгэл үзүүлж, санал бодлыг сонсох зорилгоор уулзалт зохион байгуулсан.

"Найрсаг Баруун-Урт- Театр" өдөрлөгийн үеэр 18-49 насны залуучуудын дунд сагсан бөмбөг 3х3, волейбол, 4х4 гүйлт, олс таталт, хөгжөөнт буухиа гэсэн спортын 5 төрөлт тэмцээнийг зохион байгуулж сумын хэмжээнд нийт 480 тамирчин 5 төрлийн тэмцээнд хурд, хүч, авхаалж самбаагаа дайчилж нийт онооны дүнгээр тэргүүн байранд 7-р баг, дэд байранд 1-р баг орж амжилт үзүүлсэн.

Ахмадын шатар, ширээний теннис, дартс, софт волейбол, граунд гольф, хавчаахай харваа, шугаман бүжиг зэрэг 7 төрлөөр давхардсан тоогоор 288 ахмад авхаалж самбаа, ур ухаан, хүч чадлаа сорин оролцсон.

Ахмадын тэмцээнд Баруун-Урт сумын Тамгын газраас 1000000 төгрөг, аж ахуй нэгжүүдээс 1120000 төгрөгийн дэмжлэг нийт 2120000 төгрөгийг дэмжлэг олгосон. Тус тэмцээнд амжилттай оролцон байр эзэлсэн баг тамирчдад "Ахмад-2022" аймгийн спортын тэмцээнд оролцох эрхийн бичиг, өргөмжлөл, медаль гардуулсан.

Аймгийн Нийгмийн даатгалын газартай хамтран иргэд, даатгуулагчдад эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг таниулах, үйлчилгээг нэг дороос үзүүлэх, эрүүл мэндийн даатгалын ач холбогдол, талаар ойлголт өгөх, иргэдийн санал хүсэлтийг шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулсан. Уг арга хэмжээнд 650 иргэн оролцож мэдээлэл, үйлчилгээ авсан.

Эрүүл мэндийн чиглэлээр: Улаанбаатар хотоос "Марал эрүүл мэндийн төв"-ийг урьж хөдөөгийн 8 дугаар багт "Урьдчилан сэргийлэх үзлэг" 2 өдрийн турш 11 төрлийн үйлчилгээг 16 хүний бүрэлдэхүүнтэй 320 гаруй иргэнд малчины хотонд зохион байгуулсан. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан нийт эмэгтэйчүүдийн 18.5% хоёрдогч үргүйдэл, эрт цэвэршилт, жирэмслэлтээс хамгаалах арга хэрэгслийн буруу хэрэглээ, мэдлэг хомс бөгөөд жирэмслэлтээс хамгаалах дааврын тарианы буруу хэрэглээ их, чих хамар хоолойн архаг үрэвсэл их, эрэгтэйчүүдийн үзлэгээр 80% бэлэг эрхтэний ариун цэвэр муу, түрүү булчирхайн томрол, давхар бөөрний шохойжилт 5%, бөөрний хавдар 1%, бөөрний бусад өвчин 42% эзэлж байгаа бөгөөд эрэгтэйчүүдийн

голлох өвчин нь бэлэг эрхтэний хөвчрөл муудсан, арьсний дутмагшил үргүйдэлүүд зонхилж байсан.

Хүүхдийн үзлэгт 32 хүүхэд хамрагдсан ба 2 хүүхэд халуурсан, хоолойны улайлттай, хоолойны махтай байсан ба өсвөр насны 4 хүүхдийн өсөлт хоцрогдолтой байсан.

Уламжлалт болон барианы хураангуй дүгнэлт 160 хүн эмэгтэй, 60 эрэгтэй, 100 цул сав, үе мөчний өвдөлт, хуян шар усны өвчин, хүзүү нурууны яс ургалттай гэсэн оноштой байна. Нийт үзлэгт хамрагдсан иргэдэд эрүүл мэндийн зөвлөгөө өгч, эмчилгээ заасан. Засаг даргын А/59 дугаар захирамжаар Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг шинэчилэн зохион байгуулж нөхөрллийн хэлбэрт шилжүүлсэн.

Найрсаг Баруун-Урт-Театр өдөрлөгийн хүрээнд “Энэрэл ачтан” “Энхлэн ачтан” Өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран 130 иргэнийг ХДХВ/ДОХ, БЗДХ, -ээс урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд хамруулсан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн “Эрхэм ертөнц” эцэг эхийн зөвлөлтэй хамтран тусгай хэрэгцээт хүүхдүүдийн асран хамгаалагч нарт мэргэжлийн сэтгэл зүйчийн зөвлөлгөө өгөх ажлыг зохион байгуулсан. Тус арга хэмжээнд 30 иргэн хамрагдаж зөвлөгөө авсан.

Хот төлөвлөлт, ногоон байгууламжийн чиглэлээр: Аймгийн төвд орж ирсэн малын мэдээллийг 99046256 утсаар тогтмол хүлээн авч байна. Мөн нийтийн эзэмшлийн зам талбайд байгаа малыг түр хаших арга хэмжээ авсан. Энэ сард давхардсан тоогоор 90 гаруй адууг хашиж иргэнд холбогдох мэдээ мэдээллийг өгч ажилласан.



Энэ сард Баруун-Урт сумын хэмжээнд нийт 20 ширхэг золбин нохой устгасан. Устгалыг Байгаль хамгаалагчийн хяналтан дор хийж гүйцэтгэсэн.



Тэрбум мод үндэсний хөдөлгөөн бүх нийтээр мод тарих аяны хүрээнд хаврын



тарилтаар Баруун-Урт сумын хэмжээнд нийт 42446 ширхэг модны суулгацыг шинээр тарьсан. Уг модны ургалтыг тодорхойлох зорилгоор сумын Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн А/294 тоот захирамжийн дагуу ажлын хэсэг томилогдон модны мониторинг хийсэн. Хаврын тарилтаар иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 9 багийн 126 өрхөд 3734 ширхэг суулгацыг зах зээлийн үнээс 50%-ийн хөнгөлөлттэй олгосон. Уг модны суулгацад мониторинг хийхэд 3100 ширхэг нь ургасан, 634 ширхэг нь ургалтгүй болсон байна. Нийт амьдралын хувь 83%-тай.

Төв суурин газарт хаврын тарилтаар 21813 ширхэг суулгацыг тарьсан. Үүний 20890 ширхэг суулгац нь ургасан, 923 ширхэг суулгац нь ургаагүй. Нийт ургалт 96%-тай.

Орчин тойрон болон бичил цэцэрлэгт хавар 10614 ширхэг суулгац тарьсан. Үүний 10540 ширхэг ургасан, 74 ширхэг суулгац нь үхсэн. Амьдралын хувь 99%-тай.

Нэрэмжит төгөлд 5285 ширхэг суулгац тарьснаас 4900 ширхэг ургасан, 385



ширхэг нь ургаагүй. Амьдралын хувь нь 93%-тай. Хамгаалалтын зурваст 1000 ширхэг суулгац тарьсан. Үүний 303 ширхэг ургасан. Ургалт 30%-тай.

Улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр усалгаа арчилгаа хийж гүйцэтгэж байгаа 3 аж ахуй нэгж байгууллагын модонд мониторинг хийлээ.



Баруун-Урт цэцэрлэгжүүлэлт ойн анги ОНӨААТҮГазар нь нийт 8083 ширхэг модыг хариуцан усалгаа арчилгааг хийж гүйцэтгэж байна. Үүнээс 5269 ширхэг нь ургалттай, 2814 ширхэг нь ургалтгүй байна. Нийт ургалт 65%-тай. 4,5-р тойргийн модны тоо дутуу.

Ойжуулалт Хайлаас ХХК нь нийт 5637 ширхэг модыг хариуцан усалгаа арчилгааг хийж гүйцэтгэж байна. Үүний 5207 ширхэг нь ургалттай, 430 ширхэг нь ургалтгүй байна. Нийт ургалт 92%-тай.

Шаргын модод ХХК нийт 8465 ширхэг модыг хариуцан усалгаа арчилгааг хийж



гүйцэтгэдэг. Үүний 8239 ширхэг нь ургалттай, 226 ширхэг нь ургалтгүй байна. Нийт ургалт 97%-тай байна.

Усалгаа арчилгаа хийж гүйцэтгэж байгаа аж ахуй нэгж байгууллагуудын ногоон байгууламжийн ургалтын хувь нь 85%-ийн ургалттай байна.

5 дугаар багийн хуучин ЗХ-ний 0168 дугаар ангийн урд талын зам дагуу 11 айл өрхийн хашааг бетон хашаагаар сольж, шинэчлэх ажлыг иргэн Н.Мөнх-Эрдэнэтэй гэрээг байгуулан хашаажуулах ажлыг хийж гүйцэтгүүлж байна. Ажлын явц 90%-тай байна.

ОНХС-ийн хөрөнгөөр Худалдааны гудамжны тохижилтын ажлыг Молцог элс ХХК хийж гүйцэтгэж байна. Ажлын явц 90%-тай байна.



Дэмжлэг, буцалтгүй тусламж:Тайлант сарын хугацаанд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоотойгоор нийт 101 иргэнд 7340000 мянган төгрөгийн тусламж, дэмжлэгийг олгосон.Үүнд:

- Тайлант сард тус Тамгын газраас гэрийн гачигдалтай 3 иргэнд тус бүр 150,000

- 2022-2023 оны хичээлийн шинэ жилийг тохиолдуулан Хөгжлийн бэрхшээлтэй 20 хүүхдэд тус бүр 100000 мянган төгрөгийн хичээлийн хэрэгсэл авах эрхийг бичиг
- 3-р багийн аймгийн ИТХ-ын төлөөлөгч Б.Гантулга 2022-2023 оны хичээлийн жилд 1-р ангид элсэн суралцах 42 хүүхдэд 5400000 мянган төгрөгийн өртөг бүхий цүнх, хичээлийн хэрэгсэл,
- 2-р багийн ажлын алба, аймаг сумын ИТХ-ын төлөөлөгчид, аж ахуй нэгж байгууллагуудтай 12 хүүхдэд 960.000 мянган төгрөгийн өртөг бүхий хичээлийн хувцас
- Номин агуулах худалдаа Сүхбаатар салбарын ажилчдаас 5 өрхөд хүнсний дэмжлэг
- 9-р багийн иргэн Б.Цолмон зорилтот бүлгийн өрхийн хүүхдэд форм, дээл, гутал
- “Хүслэн” хүүхдийн оролцооны байгууллагаас А.Бямбасүрэнд хичээлийн хэрэгсэл
- 9-р багийн иргэн Т.Идэрбаяр 20 эмэгтэй хүүхдийн гутал 600.000 төгрөгний үнэ бүхий хувцас
- Сумын хурлын төлөөлөгч Г.Ган-Оюу багийн иргэн Ц.Цэцэгээгийн эмчилгээний зардалд 30.000 төгрөгийг тус тус олгосон.

Төсөл хөтөлбөр: Монгол Улсын аварга Бүрэнтөгсийн санаалчилгаар 21 аймагт

хэрэгжүүлж буй
Бүрэн Монгол
төсөлд Баруун-Урт
сумын 11 өрхийн
материалыг
илгээснээс 6-р
багийн өрх
сонгогдож ирсэн.
Төслийн багаас
сонгогдсон өрх буюу
6-р багийн иргэн
Б.Болдбаатрын гэр



бүлд 20 сая төгрөгний үнэ бүхий 6 ханатай монгол гэрийг иж бүрэн тавилгын хамт гардуулан өгсөн. Аймгийн ГБХЗХГазраас хуримын ёслол, хүлээн авалтыг зохион байгуулж, тамгын газраас хүндэтгэл үзүүлж хамтран ажиллалаа.

Найрсаг баруун-урт театр”

өдөрлөг:Тус Тамгын газраас санаачилан Жаахан шарга театртай хамтран 9-р сарын 10, 11-ний өдрүүдэд “Найрсаг Баруун-Урт-театр” өдөрлөгийг аймгийн баяр наадмын төв талбайд зохион байгууллаа. Өдөрлөгт 58 төрийн байгууллага, 38 аж ахуйн нэгж, 5000 гаруй иргэн оролцож, үйл ажиллагаагаа сурталчилан танилцуулж, иргэдэд үйлчилгээ үзүүлж ажилласан.

Мөн тус сумын харьяа 11 цэцэрлэг, 4 сургууль, аймгийн МСҮТөв нь 168 төрлийн хүнс, бараа бүтээгдэхүүнээр үзэсгэлэн гаргаж, 9232500 төгрөгийн бүтээгдэхүүнийг борлуулж, орлого олсон.

38 үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэгч, баялаг

бүтээгчид

оролцож,

бүтээгдэхүүн,

үйл ажиллагааг

сурталчлах,

худалдан

борлуулах үйл

ажиллагаа

явуулж

11500000 мянган төгрөгийн бараа бүтээгдэхүүнийг

борлууллаа. Найрсаг Баруун-Урт өдөрлөгийн азтан шалгаруулах сугалааг аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгчид ивээн тэтгэж, нийт 1750 гаруй иргэн оролцож, 36 иргэн 50.000 төгрөг, 18 иргэн 100.000 мянган төгрөг болон гарын бэлэг, супер азтан 300.000 мянган төгрөгөөр 2 иргэн тодорч шагналыг гардууллаа.Мөн

- 80 жилийн ойн медалиар 44 иргэн
- Сумын ИТХ-н “Хүндэт өргөмжлөл”-өөр 5 иргэн
- Баруун-Урт сумын “Баярын бичиг”-ээр 9 иргэн
- Сумын Иргэдийн хурлын “Хүндэт тэмдэг”-ээр 4 иргэн.
- Аймгийн Засаг даргын “Баярын бичиг”-ээр 3 иргэн
- Аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр 1 иргэн тус тус шагнагдсан.

Тайлан нэгтгэсэн:

Хууль эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн:

А.Өлзийжаргал

